

## ГАРЧИГ

БҮЛЭГ 1. ТӨСЛИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА .....	3
1.1. Төслийн товч тодорхойлолт, хүчин чадал:.....	7
1.1.2. Төслийн үр ашиг.....	10
1.1.4.Түүхий эд бэлтгэн нийлүүлэлт: .....	12
1.1.5.Төсөл хэрэгжих орчны дэд бүтэц.....	16
БҮЛЭГ 2. ТӨСЛИЙН ТАЛБАЙ, ТҮҮНИЙ ОРЧНЫ БАЙГАЛЬ ОРЧИН, НИЙГЭМ ЭДИЙН ЗАСГИЙН ТӨЛӨВ БАЙДЛЫН ТОВЧ ТОДОРХОЙЛОЛТ .....	17
2.1 Монгол орны уур амьсгал .....	17
2.2 Улаанбаатар хотын уур амьсгалын горим.....	17
2.3 Салхины горим.....	18
БҮЛЭГ 3. ТӨСЛИЙН ГОЛ БА БОЛЗОШГҮЙ СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙН ТОВЧ ТОДОРХОЙЛОЛТ.....	22
3.1 Нөлөөллийн хэлбэр үргэлжлэх хугацаа.....	22
БҮЛЭГ 4. БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТУХАЙН ЖИЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ГОЛ ЗОРИЛТ .....	24
5. СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ .....	25
6. ОРЧНЫ ТОХИЖИЛТ, НӨХӨН СЭРГЭЭЛТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ.....	27
7. ТҮҮХ, СОЁЛЫН ӨВИЙГ ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ .....	27
8. ОСОЛ ЭРСДЭЛИЙН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ.....	28
9. ХОГ, ХАЯГДЛЫН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ .....	30
10. ОРЧНЫ ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭНИЙ ХӨТӨЛБӨР .....	31
11. ТУХАЙН ЖИЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨГ ХЭРЭГЖҮҮЛЭХ УДИРДЛАГА ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨ.....	33
12. ТУХАЙН ЖИЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТИЙГ НӨЛӨӨЛЛИЙН БҮСИЙН ОРШИН СУУГЧДАД ТАЙЛАГНАХ ТӨЛӨВЛӨГӨӨ.....	34

## ЗУРГИЙН ЖАГСААЛТ

Зураг 1. Засаг захиргааны зураг .....	4
Зураг 2. Төслийн талбайн ерөнхий байршлын зураг .....	5
Зураг 3. Төслийн талбайн районы агаар, сансрын зураг .....	6
Зураг 4. Үйлдвэрийн технологи .....	10
Зураг 5. Үйлдвэрийн тоног төхөөрөмж .....	12
Зураг 6. Төслийн хүрээнд ашиглах түүхий эд .....	13
Зураг 7. Төслийн талбайн фото зураг .....	15
Зураг 8. Улаанбаатар хотын уур амьсгалын горим .....	18
Зураг 9. Салхины хурдны жилийн явц .....	19
Зураг 10. Салхины зүгийн давтагдал улирлаар (НЗДТГ, 2018) .....	19
Зураг 11. Агаарын температур болон хур тунадасны олон жилийн өөрчлөлт .....	20
Зураг 13. Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр .....	32

## ХҮСНЭГТИЙН ЖАГСААЛТ

Хүснэгт 1. Төслийн талбайн эргэлтийн цэгүүд .....	3
Хүснэгт 2. “Био Деградебль Материал” ХХК-ийн түүхий эдийн мэдээлэл .....	9
Хүснэгт 3. Төслийг хэрэгжүүлэх үе шат .....	9
Хүснэгт 4. Үйлдвэрийн хүчин чадал .....	13
Хүснэгт 5. Үйлдвэрлэлийн хүчин чадал ашиглалтын хувь \бүтээгдэхүүн\ .....	13
Хүснэгт 6. Тоног төхөөрөмжийн судалгаа .....	14
Хүснэгт 7. Болзошгүй нөлөөллийн хэлбэр, үргэлжлэх хугацаа, эрчим ба эх үүсвэр .....	22
Хүснэгт 8. Байгаль орчныг хамгаалах төлөвлөгөөний нэгтгэл .....	24
Хүснэгт 9. Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө .....	25
Хүснэгт 10. Орчны тохижилт, нөхөн сэргээлтийн төлөвлөгөө .....	27
Хүснэгт 11. Эрсдэлийн менежментийн төлөвлөгөө .....	28
Хүснэгт 12. Хог хаягдлын менежментийн төлөвлөгөө .....	30
Хүснэгт 13. Орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийн хуваарь .....	31
Хүснэгт 14. Тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөө .....	33
Хүснэгт 15. Тухайн жилийн БОМТ-ний хэрэгжилтийг нөлөөллийн бүсийн оршин суугчдад тайлагнах төлөвлөгөө .....	34

## БҮЛЭГ 1. ТӨСЛИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

Улаанбаатар хотын Сонгинохайрхан дүүргийн 32-р хорооны нутагт байрлах “Био Деградебль Материал” ХХК-ийн “Малын гаралтай өөх, тос боловсруулах үйлдвэр” төслийн байгаль орчны, төлөв байдлын үнэлгээний тайланг хамтран ажиллах гэрээний дагуу байгаль орчны үнэлгээ, судалгааны “Баялаг Баян Ундарга” ХХК боловсруулав.

“Био Деградебль Материал” ХХК нь “ДөДэЦэ” ХХК-тай хамтран ажиллах гэрээ байгуулж, агуулах түрээсэлж байна.

**Төслийн нэр:** “Малын гаралтай өөх, тос боловсруулах үйлдвэр” төсөл

**Төсөл хэрэгжүүлэгчийн ерөнхий мэдээлэл:**

**Төсөл хэрэгжүүлэгчийн нэр**

- “Био Деградебль Материал” ХХК
- Хувийн хэргийн дугаар: 9011816482
- Регистрийн дугаар: 6548393

**Төсөл хэрэгжүүлэгчийн хаяг, утас**

- Улаанбаатар хот, Хан-Уул дүүрэг, 18-р хороо, Хүннү-2222, их монгол усл, 117, 1103
- Утас: 99025449

**Компанийн хэлбэр**

- Хязгаарлагдмал хариуцлагатай компани

**Байгуулагдсан он**

- 2020.03.24

**Харьяалал**

- Монгол

**Төслийн байршил:**


“Био Деградебль Материал” ХХК-ийн “Малын гаралтай өөх, тос боловсруулах үйлдвэр” төслийн талбай нь Улаанбаатар хотын Сонгинохайрхан дүүргийн 32-р хороонд байрлана.

- Талбайн хэмжээ: 5971 м<sup>2</sup>
- Талбайн байр зүйн зургийн нэрэлбэр: L-48-10


**Газарзүйн солбицол**

Хүснэгт 1. Төслийн талбайн эргэлтийн цэгүүд

№	Уртраг			Өргөрөг		
	Градус	Минут	Секунд	Градус	Минут	Секунд
1	106	35	31.6	47	53	6.6
2	106	35	31.9	47	53	8.9
3	106	35	31.0	47	53	9.6
4	106	35	32.8	47	53	11.0
5	106	35	34.0	47	53	10.0
6	106	35	35.5	47	53	8.6
7	106	35	33.6	47	53	7.6



Зураг 1. Засаг захиргааны зураг



Зураг 2. Төслийн талбайн ерөнхий байршил зург



Зураг 3. Төслийн талбайн районы агаар, сансрын зураг

### 1.1. Төслийн товч тодорхойлолт, хүчин чадал:

Төсөл хэрэгжүүлэгч “Био Деградебль Материал” ХХК. Хүн төрөлхтний амьдралын хэв маягийг өөрчилж буй органик шилжилтийн нэгээхэн хэсгийг бүтээлцэхээр 2020 онд үүсгэн байгуулагдсан “Био Деградебль Материал” ХХК нь байгальд ээлтэй, хүний эрүүл мэндэд сөрөг нөлөөгүй, пластик агуулаагүй, хог болон хаягдахдаа хөрсөнд бордоо болон задардаг БОРДУ савыг Монгол улсын зах зээлд амжилттай нэвтрүүлэн, үйл ажиллагаагаа явуулан эхэлсэн цагаас хойш нийгмийн хариуцлага дээдэлдэг, бизнесийн үнэ цэнээ бүтээж буй олон олон харилцагчдыг эгнээндээ нэгтгэн урагшилсаар байна. Нийт 200 гаруй ресторан, байгууллага, хувь хүмүүст хүрч харилцагчдаа болгон ажиллаж байгаа бөгөөд сүлжээ дэлгүүрүүдэд мөн бараа бүтээгдэхүүнээ тараан хэрэглэгчдэд хүрэх сувгаа өргөтгөсөөр байна.

Дэлхий дээрх хамгийн хурдан ургадаг ургамлуудын нэг, шавхагдашгүй нөөц баялаг болсон хулс болон чихэр өвсний шахдсаар бүтээгддэг БОРДУ савыг дэлхийн эдийн засгийн тэргүүлэгч гүрэн болох БНХАУ-д үйлдвэрлүүлдэг бөгөөд жилд 34 нэр төрлийн 20 тэрбум сав үйлдвэрлэх хүчин чадалтай Кьюанлин группийн Монгол дахь албан ёсны агентлаг болсон билээ.

“Манай улс жилд 18 сая орчим толгой мал нядалж жилд 33,000-35,000 тн дотор гадар өөх гардаг. Энэ өөхний дийлэнх хэсэг хаягдал болон хаягддаг. Учир нь сүүлийн жилүүдэд иргэд өөх идэхээ больсон бөгөөд уг өөхийг худалдан авах боловсруулах газар байхгүй учир хаядаг. Эдгээр хаягдал өөх нь хогийн цэгүүд дээр байгаль орчныг ихээр бохирдуулж байна. Тиймээс манай ХХК нь малын өөх тосыг боловсруулж малын гаралтай түүхий гарган авч БНХАУ-ын “Хэнань Жианхуан” үр тариа, өөх тосны машин механизмын үйлдвэрт нийлүүлэхээр гэрээ хийн үйлдвэрээ байгуулахаар ажиллаж байна. Манай компани нь үйл ажиллагаа явуулах үйлдвэрийн байртай. Мөн өөх боловсруулах үйлдвэрийн тоног төхөөрөмжийг өөрийн хөрөнгөөр худалдан авсан байгаа. Гэвч зарим туслах тоног төхөөрөмж, агуулах байхгүй байгаа бөгөөд агуулахын байр барих, нэмж тоног төхөөрөмж авахаар энэхүү төслийг боловсруулж байна.

**Зорилго:** Малын өөх тосыг боловсруулж тос ялган авах үйлдвэр байгуулах, шинэ дэвшилтэт техник технологийг нэвтрүүлэх, өөхөн тосыг технологийн дагуу үйлдвэрлэж брэнд бүтээгдэхүүн гаргах, нэгж малаас гарах ашиг шимийг нэмэгдүүлэх, хог хаягдлыг багасгах, ажлын байр бий болгох, экспортын орлогыг нэмэгдүүлэх эх орныхоо хөгжил цэцэглэлтэд хувь нэмэр оруулж, компанийн үйл ажиллагааны хүрээг тэлэн үнэ цэнийг нэмэгдүүлэх нь энэхүү төслийн эрхэм зорилго болно.

#### **Зорилт:**

- Стандарт шаардлага хангасан агуулахтай болох
- Сүүлийн үеийн дэвшилтэт технологи бүхий тоног төхөөрөмж суурилуулах
- Өөхийг стандартын дагуу боловсруулж тос гарган авах
- Тосыг дотоодын савангийн үйлдвэр болон хүнсний үйлдвэрүүдэд нийлүүлэх
- Гадаад зах зээл рүү нийлүүлэх
- Өөх боловсруулахад гаргасан шимэлдгийг гахайн фермерт нийлүүлэх
- Бүтээгдэхүүний нэр төрлийг олшруулах
- Үйлдвэрийг бүрэн хүчин чадлаар ажиллуулах
- Шинээр 14 хүний байнгын ажлын байр бий болгох.

- Олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн технологиор малын гаралтай бүтээгдэхүүнийг аюулгүй орчинд төрөлжүүлэн хадгалах, түгээх сүлжээг өөрийн орны онцлогт тохируулан цоо шинээр бий болгох
- Байгалд ээлтэй ногоон үйлдвэр бий болгон тус салбарт жишиг үйлдвэр болох
- Хүнсний үйлдвэрийн стандарт MNS, ISO, HACCP, GMP болон эрүүл ахуй, ариун цэврийн шаардлага хангасан бүтээгдэхүүнийг үйлдвэрлэж, хэрэглэгчдэд хүргэх
- Борлуулалтын сувгийг хөгжүүлэх болон оновчтой тогтоож, гадаад харилцаа холбоогоо тогтмол хөгжүүлэх
- Үйлдвэрийн дараагийн үе шатуудад өөрөө өөрийгөө санхүүжүүлэх чадвартай болох
- Үндэсний үйлдвэрлэлийг хөгжүүлэхэд хувь нэмрээ оруулах
- Улсынхаа өрсөлдөх чадварыг нэмэгдүүлэх

#### **1.1.1. Төслийн нийт хөрөнгө оруулалт**

- Төслийн нийт хөрөнгө оруулалт: 451,900,000 төгрөг.
- Санхүүжилтийн эх үүсвэр: Гаднын санхүүжилтээр 65,9% буюу 298,000,000 төгрөг, өөрийн хөрөнгөөр 34,1% буюу 153,900,000 төгрөгийг санхүүжүүлэх саналтай байна.
- Хөрөнгө оруулалтын зарцуулалт: Үндсэн хөрөнгө болох агуулахын байр тоног төхөөрөмж худалдан авах
- Хөрөнгө оруулалтын нөхөн төлөх хугацаа: 5 жил
- Хөнгөлөлтийн хугацаа: 1 жил
- Зээлийн хүү: Жилийн 3%
- Өр зээл байгаа эсэх: 30 сая төгрөгийн зээл
- Үйлдвэрлэх бүтээгдэхүүний нэр төрөл:
  - Өөх боловсруулж малын гаралтай түүхий эд гарган авах
- Төсөл хэрэгжсэнээр бий болох ажлын байрны тоо: 13 хүн
- Анхны хөрөнгө оруулалтаа нөхөн төлөх хугацаа: 3 сар
- Өгөөжийн дотоод хувь: 93,3%

#### **Төслийн үндэслэл**

Монгол хүний махны хэрэглээний жилийн нормыг “сэрүүний улирлын 9 сард нэгхүн сарын бкг буюу нийт 54кг, зуны 3 сард 4,5кг буюу нийт 13,5кг, жилд нийт 67,5кг ясгүй мах хэрэглэхээр тогтоосон байдаг. (Монгол улсын Эрүүл мэндийн сайдын 2008 оны 12-р сарын 4-ний тушаал “Хүн амын хоол тэжээлийн физиологийн норм”). Энэ нь нэг хүн жилд 84кг ястай мах хэрэглэнэ гэсэн үг. Манайд хот хөдөөгийн хүн амын махныхэрэглээ өөр өөр ба дунджаар жилд 90-100кг орчим байгаа нь махны хэрэглээгээрээ дэлхийд эхний 15-р байрт ордог.

Монгол улс жилийн махны хэрэглээгээ хангах зорилгоор 18 сая толгой малнядалж 550 мянган тонн мах, 173 манган тонн дотор мах, дайвар түүхий эд гаргадаг үүний 8%-ийг үйлдвэрийн аргаар, 92%-ийг уламжлалт аргаар бэлтгэж байна.

Нядалгаанаас гарах гол түүхий эдийн гарцыг дараах хүснэгтээс харж болно. Дотор мах дайвар бүтээгдэхүүн малын амьдын жингийн 15-20 орчим хувийг эзэлдэг.



Хүснэгт 2. “Био Деградебль Материал” ХХК-ийн түүхий эдийн мэдээлэл

№	Түүхий эдийн нэр	Гарц, амьдын жинд эзлэх хувиар	
		Бод	Бог
1	Гулууз мах	47.5	40.8
2	Дотор өөх	2.5	1.6
3	Гол мах	0.96	0.6
4	Элэг	1.38	1.2
5	Бөөр	0.27	0.27
6	Зүрх	0.4	0.43
7	Сүүл	0.17	1.2
8	Гүзээ	1.7	1.9
9	Ходоод	0.46	0.43
10	Уушги	0.66	0.8
11	Дэлүү	0.17	0.19
12	Шөрмөс	0,02-0,04	
13	Шийр	1.9	1.9
14	Хар гэдэс	1 гогцоо	-
15	Өлөн гэдэс -		1 гогцоо
16	Цус	3.2	2.9
17	Сэвс	14.68	14.0

Манай улсад дотор мах дайвар түүхий эд, өөхийг боловсруулах үйлдвэр дутмаг, энэ үйлдвэрлэл нь зах зээлд шинээр хөгжиж байгаа салбар учраас үйлдвэрийн аргаар бэлтгэсэн мах бэлтгэлээс гарсан дайвар түүхий эдийг зах зээлийн эргэлтэд оруулж боловсруулж хэрэглэж чадахгүй үнэгүйдүүлэн, хаягдал бүтээгдэхүүн болгож байгаа дүр зураг Улаанбаатар хотын 3 том нядалгааны цэг болон аймгийн төвүүдийн мал нядалгааны цэгүүд дээр ажиглагдаж байна. Мөн сүүлийн үед иргэд өөх хэрэглэхээ больсон бөгөөд маш ихээр хаяж байна. Өөхөн тосыг хүнсний үйлдвэр савангийн үйлдвэр, машины тосны үйлдвэрүүд ашигладаг мөн өөхнөөс гарах шимэлдгийг гахайн фермерүүдэд нийлүүлдэг. Ямар нэг хаягдал гардаггүй.

Иймээс бид ашиглагдахгүй байгаа дотор болон гадар өөхийг зах зээлийн эргэлтэд оруулж, хямд үнэтэй түүхий эдээр үйлдвэрлэлийн өртөг шингэсэн, эрүүл ахуйн чанар стандартын шаардлага хангасан бүтээгдэхүүнийг үйлдвэрлэн Хэнань

Жианхуан үр тариа, өөх тосны машин механизмын ХХК зах зээлд нийлүүлэх зорилгоор төслийг боловсруулж байна.

Хүснэгт 3. Төслийг хэрэгжүүлэх үе шат

№	Ажлын нэр	2023-04 сараас	2023-04 сараас	2023-05 сар	2023-05 сар	2023-06 сар
1	Үйлдвэрийн байр засварлах					
2	Агуулахын байр барих					
3	Ажилчдыг бэлтгэх					
4	Түүхий эд бэлтгэх					
5	Үйлдвэрийг бүрэн ашиглалтад оруулах					

### 1.1.2. Төслийн үр ашиг

Өөх боловсруулах үйлдвэрт хөрөнгө оруулалт хийгдсэнээр бүтээгдэхүүн үйлчилгээний чанар сайжирч, үйлдвэрлэл үйлчилгээний стандарт бодит шаардлагад нийцсэн бусад үйлдвэрүүд хөгжих боломж нэмэгдэнэ. Технологи болон менежментийн шилдэг туршлага нэвтрүүлж хөгжүүлснээр тухайн салбар дахь өрсөлдөөн нэмэгдэж тоног төхөөрөмжийн шинэчлэл, бүтээгдэхүүний чанар, хөгжлийн арга барил, менежментэд дэвшил авчирна.

- Өөх боловсруулах дотоодын үйлдвэрлэлийн хүчин чадлыг нэмэгдүүлнэ
- Малаас гарах ашиг шимийг нэмэгдүүлнэ
- Хог хаягдал болоод байгаа өөхийг эргэлтэд оруулна.
- Мал нядалгааны төвүүд, албан байгууллага айл гэрээс шууд худалдаж авах учир эцсийн бүтээгдэхүүний өртөг буурч зах зээлийн ханшаас хямд үнээр худалдаанд гаргана.
- Экспортын орлогыг нэмэгдүүлнэ
- Тус салбарт технологи болон менежментийн шалгарсан туршлага нэвтрүүлнэ
- Тус салбар дахь боловсон хүчний хөгжилд тодорхой хувь нэмэр оруулна
- Тухайн салбар дахь байгальд ээлтэй үйлдвэрлэлийн зохистой мэдлэг туршлага бэхжин
- Шинээр 14 хүний ажлын байр бий болсноор дүүргийн ажилгүйдлийн түвшин бууруулах, өрхийн орлогыг нэмэгдүүлэх болон ядуурлын түвшин бууруулах чиглэлд тодорхой хувь нэмэр оруулна
- Улсын төсөв тодорхой хэмжээний татварын орлого бүрдэнэ
- Өөх боловсруулах үйлдвэр нь дараагийн үе шатуудыг өөрийн хөрөнгөөр шийдвэрлэх боломжтой болно.

### 1.1.3. Үйлдвэрлэлийн технологи



Зураг 4. Үйлдвэрийн технологи



Өндөр даралттай халуун ус хөргөгч



Ус хөргөх танк



Тосны танк



Өөхний тогоо



Хаягдал өөх хуримтлуулах сав



Тос хуримтлах сав



Тосны хэв

Зураг 5. Үйлдвэрийн тоног төхөөрөмж

### 1.1.4. Түүхий эд бэлтгэн нийлүүлэлт:

Монгол улс жилд 450 орчим мянган тонн мах бэлтгэдэг ба ойролцоогоор 18 сая толгой мал нядалдаг үүний 92% хувь нь бог мал, 8% бод мал байдаг. Эдгээрээс малаас жилд дотор болон гадар өөх жилд 33,000-35,000 тн гарна гэсэн тооцоолол байна. Энэ бүхэн нь манай үйлдвэрийн түүхий эдийн нөөц хир их байгааг харуулж байна. /эх сурвалж: Статистикийн үндэсний хороо 2021 он/ Бид түүхий эдээ нийслэлийн түүхий эдийн “Эмээлт” болон нийслэлийн хүнсний “Дэнжийн мянга” зах болон зарим аймаг, орон нутаг, Налайх зэрэг төв суурин газрын зах, мал нядалгааны газрууд болон facebookд зар байршуулж өөрийн үйлдвэрийн байран дээр худалдан авна. Нэг кг малын өөхний үнэ 600-800 төгрөгийн ханштай байгаа бөгөөд бид төсөлд эрсдэлийг тооцож кг-ийг 800 төгрөгөөр авахаар тооцсон болно.

### Малын өөх тосны давуу тал

Эрүүл бэлчээрийн малаас авсан өөх тос, мөн дотор өөх нь зүрхний өвчин, хорт хавдар, холестерол ихсэх, таргалалт гэх мэтийг үүсгэдэггүй. Төрөл бүрийн амьтны гаралтай өөх нь хүний биед хэрэгтэй бүрийг өгч чаддаг байна.

### Тосны төрөл, хүнсэнд хэрэглэх тос, дараах хэдэн янз байна:

**Ханасан тос (saturated fats):** Өрөөний дулааны хэмд хатуу байдлаар байх ба ихэнхдээ амьтны гаралтай тос байдаг. Жишээлбэл өөхөн тос, цөцгийн тос, шар тос, тосыг аваагүй сүүн бүтээгдэхүүн, маргаринд байна. Энэ тос нь хүний цусан дахь муу холестиринийг ихэсгэх ба хүнд үзүүлэх ашиг нь бага байна. Ханасан тос зарим нэг төрлийн хавдар болон зүрх судасны өвчнийг үүсгэх нөхцөлийг бүрдүүлдэг.

**Ханаагүй тос (unsaturated fats):** Ихэвчлэн өрөөний дулааны хэмд шингэн байдлаар байх ба холестириний сайн төрлийг нэмэгдүүлж зүрх судасны өвчнөөс сэргийлнэ. Ханаагүй тос нь “Моно ханаагүй тос” (monounsaturated), “Поло ханаагүй тос” (polyunsaturated) гэж хоёр янз байна.

### Үхрийн өөх

- **Түүхий өөх:** Түүхий үхрийн өөх нь цайвар шаргал өнгөтэй цагаан өнгөтэй, үйрч унадаг, харьцангуй хөнгөн жинтэй байдаг. Дээр нь махны үлдэгдэл, холбогч эд, эсвэл арьсны үлдэгдэл байна.

- **Болсон өөх:** Цагаан, цөцгий шиг өнгөтэй байх ёстой. Хэт ханасан тул өрөөний температурт хатуурч хэврэг болдог. Та үүнийг хутгаж авч чадахгүй тул огтлох хэрэгтэй болно.

**Хүнсэнд хэрэглэх заавар:** Үхрийн өөх бол хоол хийхэд хамгийн тохиромжтой тоснуудын нэг юм. Их хэмжээнд ханасан, бага хэмжээний ханаагүй өөх тос агуулдаг халуун хоол хийхэд нэн тохиромжтой. Маш зөөлөн үхрийн махны амттай учраас бараг ямар ч ногоо, эсвэл өндөгтэй хоолонд хэрэглэж болно.

**Өөхний найрлага:** Ханасан өөх тос: 50 хувь Моно ханаагүй тос: 42 хувь Поло ханаагүй тос: 4 хувь

### Хонины өөх

Хонины сүүлний бүдэрхийнээс дээш дөрвөн хуруу орчим, өндөр нягтаршилтай хэсэг нь хэт ханаагүй тосны хүчил агуулсан байдаг ажээ. Хэт ханаагүй тос нь хүний биед маш сайн шингэдэг.

Хонины сүүлэнд агуулагддаг Д, С, А, К аминдэмүүд сульдаа, элдэв хордлого, харшил, харааны хөгжилд эергээр нөлөөлж цус багадалтаас сэргийлдэг. Харин хонины өвчүүний хэрсэнгийн өөх нь ханаагүй хүчил ихтэй, царцах нь удаан, тэжээллэг чанар өндөр, кальци ихтэйг судалгаагаар тогтоосон.

**Өөхний найрлага:** Ханасан өөх тос: 45 хувь Моно ханаагүй тос: 45 хувь Поло ханаагүй тос: 10 хувь



Зураг 6. Төслийн хүрээнд ашиглах түүхий эд

### Хүснэгт 4. Үйлдвэрийн хүчин чадал








№	Бүтээгдэхүүний нэр	х/н	Өдөрт боловсруулах хүчин чадал	Өдөрт гаргаж авах өөхөн тос	Жилийн хүчин чадал
1	Малын гаралтай түүхий эд	тн	20	14	4368

/Ажлын 26 хоногоор бодов./ Малын өөхийг хайлуулахад 1 кг өөхнөөс 70 хувийн тос гарч, үлдсэн 30 хувь нь шимэлдэг буюу ялгарсан хальс байдаг.

### Хүснэгт 5. Үйлдвэрлэлийн хүчин чадал ашиглалтын хувь \бүтээгдэхүүн\

№	Бүтээгдэхүүний нэр	х/н	Төслийн эхний жил	Төслийн2 дахь жил	Төслийн3 дахь жил	Төслийн4 дахь жил	Төслийн 5дахь жил
	Хувь		50%	50%	50%	60%	60%
1	Хонины өөхөнтос	тн	2184	2184	2184	2620	2620

Хүснэгт 6. Тоног төхөөрөмжийн судалгаа

№	Төхөөрөмжийн нэр	Үзүүлэлт	Тоо ширхэг	Хүчин чадал	Зураг	Тайлбар
1	Битүүмжилсэн тогоо	AYG1500*3000	2			Тоног төхөөрөмжийн үзүүлэлт нь Ø1500X3000 багтаамжтай.
2	Хурд бууруулагч	JSJ-4-3	2	3		Редуктор нь тогоонд дотоод эргэлтийн хүчийг өгдөг бөгөөд техникийн харьцааны хурд нь бүтээгдэхүүний чанарыг сайжруулдаг.
3	Тосны үлдэгдэл ялгах хусуур	GB300	1	2.2		
4	Тосны үлдэгдэл сайжруулах Төхөөрөмж	TSJ300	1	2.2		
5	Гидравликтос дарагч	SSJ165	1	4		
6	Халуун хэмжүүр		1	-		Мэдрэгч электрон дижитал термометр нь тодорхой уншилттай бөгөөд төхөөрөмжийн температурыг ажиллуулахад хялбар байдаг.
7	конденсатор лагч	LNQ50	1			
8	Усны насос	SB80-50-160	1	7.5		

№	Төхөөрөмжийн нэр	Үзүүлэлт	Тоо ширхэг	Хүчин чадал	Зураг	Тайлбар
9	Үнэр арилгагч цамхаг	ССТ800	1			
10	усны насос	SB50-40-160	1	3		
11	вакум насос		1	-		
12	Шинэ материал тэжээх Хусуур		1	2.2		
13	Түгээх кабинет		1			



Зураг 7. Төслийн талбайн фото зураг

#### **1.1.5.Төсөл хэрэгжих орчны дэд бүтэц**

- *Усан хангамж:* Зөөврөөр хангана;
- *Бохир ус зайлуулах:* Зориулалтын Ёмксонд хуримтлуулаад тогтмол соруулдаг;
- *Цахилгаан хангамж:* Төвлөрсөн эх үүсвэрээс хангана;
- *Дулаан хангамж:* Тениэр халаана.



## БҮЛЭГ 2. ТӨСЛИЙН ТАЛБАЙ, ТҮҮНИЙ ОРЧНЫ БАЙГАЛЬ ОРЧИН, НИЙГЭМ ЭДИЙН ЗАСГИЙН ТӨЛӨВ БАЙДЛЫН ТОВЧ ТОДОРХОЙЛОЛТ

### 2.1 Монгол орны уур амьсгал

Монгол орон гадаад далай тэнгисээс ихээхэн алслагдсан, Евроазийн эх газрын төвд тал бүрээсээ өндөр уул нуруугаар хүрээлэгдсэн, далайн түвшнээс өндөр өргөгдсөн зэргээс шалтгаалан эх газрын эрс тэс, хатуу ширүүн уур амьсгалтай. Уур амьсгалын гол онцлог нь жилийн дөрвөн улирлын ялгаа ихтэй, энэ чанараараа агаарын температурын хэлбэлзэл өндөр, хур тунадас бага, уур амьсгалд өргөргийн болон өндрийн бүслүүрийн ялгаа тодорхой илэрдэг явдал юм (УАӨҮИ, 2014). Уур амьсгалыг ихэнхдээ температур, хур тунадас, салхи зэрэг газрын гадарга орчмын цаг уурын хэмжигдэхүүнийг ашиглан илэрхийлдэг. Жилийн дундаж агаарын температур Монгол орны өндөр уулын бүс тэдгээрийн хоорондын хөндий, хоолой, томоохон голын хөндийгөөр  $-6^{\circ}\text{C}$  аас  $-8^{\circ}\text{C}$  хүртэл хүйтэн байдаг бол өмнийн говь, цөл нутагт  $6^{\circ}\text{C}$  -аас дулаан байна. Өөрөөр хэлбэл, жилийн дундаж агаарын температур нь манай орны баруун болон хойд хэсгийн уулархаг нутагт хасах, харин түүнээс урагших тал хээр говь цөлийн нутгаар нэмэх утгатай байдаг байна. Монгол орон ерөнхийдөө хуурай, хуурайвтар уур амьсгалын бүсэд орших тул хур тунадас бага ордог. Өндөр уулсын таг, тундрийн бүсэд 400 мм ээс дээш Хангайн нуруу, Хөвсгөл, Хэнтийн уулсаар 300-400 мм, Монгол Алтайн болон ойт хээрийн бүсэд 250-300 мм, хээрийн бүсэд 150-250 мм, говь цөлийн бүсэд 50-150 мм орчим хур тунадас унана. Мөн өргөн уудам нутагтай, газрын тогтоц, хотгор гүдгэрийн байдал, газарзүйн онцлог нөхцөл байдлаас шалтгаалан хур тунадас хойноос урагш, зүүнээс баруун тал руу буурдаг бөгөөд ордог хур тунадасны 80-аас дээш хувь нь дулааны улиралд түүний дийлэнх нь 7 болон 8 сард ордогдоо онцлогтой (Дагвадорж. Д, 2015).


### 2.2 Улаанбаатар хотын уур амьсгалын горим

Улаанбаатар хот нь ойт хээрийн бүсэд далайн түвшнээс дээш 1950-2265 м өндөртэй Богд-Хан, Сонгино-Хайрхан, Чингэлтэй, Баянзүрх уулын дунд Туул голын хөндийд байрладаг (Даваадорж. Д, 2020). Ерөнхийдөө өвөл нь удаан (цаас их унана), зун нь богино (аагим халуун, хур тунадас ахиухан ордог ч үе үе цочир хүйтрэн сэрүүсдэг), хавар, намар хүчтэй шуургатай өдөр тохиолддог.

Бид Улаанбаатар хотын уур амьсгалыг тодорхойлохдоо далайн түвшнээс дээш 1300 м орших “Улаанбаатар” цаг уурын станцын 1969-2019 оны хоорондох олон жилийн агаарын температур, хур тунадас, салхины хурд гэсэн статистик үзүүлэлтүүдийг ашиглалаа.

Улаанбаатар станцын дулаан, хүйтний горимыг авч үзэхэд жилийн дундаж агаарын температур  $-0.3^{\circ}\text{C}$  байгаа нь агаарын температурын хувьд сэрүүвтэр ойт хээрийн бүсэд хамаарагдах бөгөөд өвлийн улиралд  $-21^{\circ}\text{C}$ , зуны улиралд  $+19.3^{\circ}\text{C}$ -ийн хооронд хэлбэлзэнэ. Агаарын температурын жилийн амплитуд дунджаар  $23.7^{\circ}\text{C}$  орчим байна.

Агаарт цочир хүйтрэх анхны дундаж хугацаа 9 дүгээр сарын 3-р арав хоногт байх ба хамгийн эрт нь 9 дүгээр сарын 1-р 10 хоногт байна. Харин эцсийн хүйтрэлт дунджаар 6 дугаар сарын эхний 10 хоногт, хамгийн хожуу нь 6 дугаар сарын 2-р 10 хоногт тохиолдож, цочир хүйтрэлтгүй үеийн үргэлжлэх хугацаа дунджаар 137 хоног байна.




Зураг 8. Улаанбаатар хотын уур амьсгалын горим

Хаврын саруудад орох тунадасны хэмжээ аажмаар ихэссээр 5 дугаар сард ихсэж хамгийн их хур тунадас 7 сард 75.1 мм, намар 9 дүгээр сараас хур тунадасны хэмжээ огцом багасаж, 11 дүгээр сараас өвлийн гормондоо шилжиж 1 сард хамгийн бага хур тунадас буюу дунджаар 2.4 мм унадаг байна. Хоногт хэт их бороо орох, өвөл цас их унаж, хавар огцом дулаарах нь гэнэтийн үер болоход хүргэж, хөрсний эвдрэлийг ихэсгэж, зам, харилцаа, барилга, байгууламжид хор хөнөөл учруулдаг. Анхны цас дунджаар 9 дүгээр сарын 3-р 10 хоногт унах бөгөөд 11 дүгээр сарын дундаас цасан бүрхүүл тогтож, 100 орчим хоног цасан бүрхүүлтэй байж 4 дүгээр сарын эхээр цас хайлж, 5 дугаар сарын эхэн гэхэд дуусна. Сүүлчийн цас хожуудаа 5 дугаар сарын дунд арав хоногт ажиглагддаг. Цасны зузаан 2-4 см байх ба зарим хунгарласан газраа хааяа 10-20 см хүрдэг. Цасны нягт 0.16-0.30 г/см<sup>3</sup> байдаг.

Жилийн нийлбэр хур тунадас дунджаар 248 мм унадаг үүнээс дулаан улирлын нийлбэр хур тунадас 220мм буюу 89%, харин хүйтний улирлын нийлбэр хур тунадас 28мм буюу 11% ноогдох бөгөөд хур тунадасны хэмжээгээр хээрийн бүсэд хамрагддаг болохыг харуулж байна. Энэ бүс нутагт газар зүйн байрлал болон хур тунадасны хэмжээ зэргээс хамаарч агаарын чийгшил өвөл, зун (1 ба 8 дугаар сард) хамгийн их, хавар намар (4 ба 10 дугаар сард) хамгийн бага болох ба жилийн дундаж утга нь 58,6% байна.


### 2.3 Салхины горим

Судалгаанд хамрагдаж буй бүс нутагт салхины хурд олон жилийн дунджаар 2.4 м/с байдаг нь цаг агаар тогтуун бус бүс нутаг юм.




Зураг 9. Салхины хурдны жилийн явц

Салхины хурдны жилийн явцаас харахад хамгийн их болон хамгийн бага утга нь тус бүр хоёр, хоёр тохиож байна. Үндсэн хамгийн их утга нь 5 сард дунджаар 3.3 м/с, хоёрдугаар их утга нь 9 сард дунджаар 2.6 м/с ажиглагдсан бол үндсэн хамгийн бага утга нь 1 сард дунджаар 1.2 м/с, хоёрдугаар бага утга нь 7 сард дунджаар 2.7 м/с тохиодог байна.



Зураг 10. Салхины зүгийн давтагдал улирлаар (НЗДТГ, 2018)

Улаанбаатар станцын салхины зүгийн давтагдал нь тухайн орон нутгийн физик газарзүйн тогтолцооны нөлөөлөлтэй жилд дунджаар баруун хойд зүгийн салхи 47.3%-ийн давтагдалтай зонхилох боловч зүүний салхи 15.9% байгаа нь зэргэлдээх зовхисоосоо хавьгүй их давтагдалтай байна. Ялангуяа намар болон өвлийн улиралд энэ зүгийн салхи 13.0-14.3% болж зонхилох зүг болдог. Энэ зүгийн салхины давтагдал хаврын сүүл сард нэлээд буурах боловч зуны саруудад ахин нэмэгддэг (НЗДТГ, 2018).



Зураг 11. Агаарын температур болон хур тунадасны олон жилийн өөрчлөлт

1969-2019 оны олон жилийн явцаас харахад жилийн агаарын дундаж температур ойролцоогоор  $2.5^{\circ}\text{C}$ -аар дулаарсан бөгөөд уур амьсгалын өөрчлөлттэй холбоотойгоор тасралтгүй нэмэгдсээр буй нь Зураг 11-т харагдаж байна.

Энэ хугацаанд хамгийн хүйтэн жил 1969 онд  $-2.58^{\circ}\text{C}$  удаах хүйтэн жил  $-2.0^{\circ}\text{C}$  байсан бол хамгийн дулаан жил 2007 онд  $1.95^{\circ}\text{C}$  хүрч байжээ. Харин хур тунадасны олон жилийн өөрчлөлтийн хандлагаас үзвэл өссөн болон буурсан тодорхой хандлага илрээгүй бөгөөд хур тунадасны хэмжээ 166,2-395,6 мм-ийн хооронд хэлбэлзсэн ба 1966-1981, 1994-2007 онд буурч 2007 оноос эхлэн өсөх хандлагатайгаар өөрчлөгдсөн байна.

**Ус зүй:** Төслийн талбайн район нь Хойд мөсөн далайн ай сав, Туул голын сав газарт багтана.

Туул голын хөндий Улаанбаатар хотоос доош тавиурч урсцын алдагдал нэмэгдэнэ. Туул голын олон жилийн өнгөрөлт Улаанбаатар хот орчимд 25.6, Сонгинод 25.8, Өндөрширээтэд  $24.1 \text{ м}^3/\text{с}$  байна. Голын өргөн дунджаар 35-75 м, гүн 0.8-3,5 м, урсгалын хурд 0.50-1.50 м/с байна.

**Хөрсөн бүрхэвч:** Төслийн талбайд бүхэлдээ хар хүрэн хөрс тархсан байна. Химийн шинжилгээний үр дүнгээр хөрс нь шүлтлэг урвалын орчинтой, ялзмагийн агууламж бага, шингээгдэх сууриудын нийлбэр хэмжээ бага, цахилгаан дамжуулах чанар болон давсны агууламж бага, хөдөлгөөнт фосфорын хангамж бага хөдөлгөөнт калийн хангамж маш их байна.

**Ургамлын нөмрөг:** Төслийн талбайд уулын хээрийн хялгана-алаг өвст бүлгэмдэлтэй;

Ургамлын нөмрөгийн тусгаг бүрхэц 50 %,  $10 \text{ м}^2$  талбайд 10-15 зүйл ургамал тархаж, ойролцоогоор 2.0 ц/га ургацтай. Ургамлын дундаж өндөр 10-15 см. Үетэн 20 %-иар сор 1 арвитайгаар зонхилж, *Stipa krylovii* арвитайгаар сор 1, дэд зонхилж ургамал ширэг улалж 1%-иар *sp* арвитайгаар, *Artemisia dracunculus* 1%-ийн бүрхэцтэй байна;

**Ан амьтан:** Нийслэлийн ногоон бүс, түүний орчмын уулсаар экологийн олон янзын орчинд амьдардаг 17 зүйлийн хөхтөн амьтан, 82 зүйл шувуу бүртгэгджээ. Амьтны хувьд бүтээн байгуулалт, хүн амын нягтралаас үүдэн зүйл болон тоо толгой жилээс жилд цөөрч байгаа. Нийслэл хот орчмын шувуудыг тоо толгойн байдлаар авч үзвэл элбэг буюу олон

тоогоор байнга тааралддаг 8 зүйл, ердийн буюу түгээмэл тааралддаг 31 зүйл, тоо толгой элбэг бус ховор 21 зүйл, цөөн тоогоор буюу нэн ховор 22 зүйл шувуу байдаг юм байна. (Нийслэлийн байгаль орчны төлөв байдал, 2011, хуудас 108-112). Дүүрэг тус бүрээр нь зэрлэг амьтан болон шувуудын нарийвчилсан судалгаа одоогоор байхгүй байна.

#### **Хүн ам, эдийн засаг, зам харилцаа**

Сонгинохайрхан дүүрэг 120,1 га нутаг дэвсгэртэй. Нийслэлийн баруун жигүүрт Баянгол дүүрэг, Төв аймгийн Алтанбулаг, Баянчандмань, Борнуур, Батсүмбэр сумдтай хил залган оршдог. Монгол Улсын нийт хүн амын 11.6 хувь, Нийслэлийн нийт хүн амын 22.8 хувь, орон сууцны хорооллын 27.1 хувь, гэр хорооллын 72.9 хувь тус дүүрэгт байдаг.

Засаг захиргааны анхан шатны нэгж 43 хороотой. Орон сууцны 12 хороо, гэр хорооллын 22 хороо, холимог 9 хороо оршдог. Нийт 335.703 хүн амтай бөгөөд 94132 өрхтэй юм.

Дүүргийн газар нутгийн 77 хувийг хөдөө аж ахуйн эдэлбэр газар, 20 хувийг ойн сав бүхий газар, 3 хувийг зам шугам сүлжээ, барилгажсан газар тус тус эзэлдэг.

Дүүргийн хэмжээнд 83687 толгой малтай. Үүнээс тэмээ 23, үхэр 26764, адуу 13926, хонь 20917, ямаа 22057 толгой малтай байна.

Сонгинохайрхан дүүрэгт нийт үйл ажиллагаа явуулж байгаа 25865 аж ахуйн нэгж, байгууллагууд байдаг.

Нийслэлийн хүн амын хүнсний хэрэгцээний дийлэнх хувийг хангадаг Улсын хэмжээний томоохон “Сүү” ХХК, “Талх чихэр” ХХК, “Алтан тариа” ХХК, “Мах импекс” ХХК, “Тесо” ХХК, “Милл хаус” ХХК, “Арвайн үндэс” ХХК зэрэг үйлдвэр, барилгын материалын “Хангай” зах, тоосгоны үйлдвэр болон хүнс худалдаа, үйлчилгээний 12500 гаруй аж ахуй нэгж, байгууллагууд дүүргийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж байна. Эрүүл мэндийн төв, салбар 2 амбулатори, Нэгдсэн эмнэлэг, салбар 1 амбулатори, 26 өрхийн эрүүл мэндийн төвүүд болон нийт 31 нэгжид 706 гаруй эмч, сувилагч, эмнэлгийн ажилтнууд дүүргийн 342 мянга гаруй иргэнд эрүүл мэндийн анхан шатны тусламж, үйлчилгээг хүргэж байна.

2023 оны хичээлийн жилд төрийн болон төрийн бус өмчийн Ерөнхий боловсролын 35 сургуулийн 64851 суралцагч сурч байна.

2023 оны хичээлийн жилд төрийн өмчийн 65, төрийн бус өмчийн 49, нийт 112 цэцэрлэг үйл ажиллагаа явуулж байна. Нийт сургуулийн өмнөх боловсролын байгууллагад 24202 хүүхэд хүмүүжиж байна.

Гадаад харилцааны хувьд Япон улсын Изүнокүни хот, Күмамото хот, БНСУ-ын Пурён хот, Нонсан хот, Тэжон хотын Согү дүүрэг, Тэ-Ан хот, Кангбук дүүрэг, БНХАУ-ын Хөх хот, Хөлөнбуйр аймгийн Хайлаар дүүрэг, Хянган аймгийн Рашаан хот, Шилийн гол аймаг, Тайвань улсын Тайпэй хот, Турк улсын Истанбул хотын Шишли дүүрэг, Канад улс, Норвеги улс, Швейцарийн Холбооны Улс болон Австрали улсын Swarck, БНСУ-ын WESA, НААТЗ, Япон улсын “OISCO international” зэрэг олон улсын байгууллагуудтай боловсрол-спорт, соёл-аялал жуулчлал, эдийн засаг, эрүүл мэндийн салбаруудад хамтын ажиллагааны санамж бичиг байгуулан гадаад харилцаагаа өргөжүүлэн ажиллаж байна.

### БҮЛЭГ 3. ТӨСЛИЙН ГОЛ БА БОЛЗОШГҮЙ СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙН ТОВЧ ТОДОРХОЙЛОЛТ

Тус төслийн үйл ажиллагааны улмаас хүрээлэн буй орчинд учрах болзошгүй нөлөөллийг тогтоохдоо байгаль орчны суурь нөхцөл, урьд өмнө хийгдсэн байгаль, нийгэм, эдийн засгийн холбогдолтой судалгааны материалууд, судалгаа явуулсан мэргэжлийн экспертүүдийн дүгнэлтүүдийг үндэслэн тодорхойлов. Төслийн үйл ажиллагаанаас сөрөг нөлөөлөлд өртөгдөх байгалийн үндсэн тусгагдахуун нь агаар, ус, хөрс, ургамлын нөмрөг юм.

#### 3.1 Нөлөөллийн хэлбэр үргэлжлэх хугацаа

Төслийн үйл ажиллагаанаас байгаль орчны төлөв байдалд үзүүлж болзошгүй болон гол сөрөг нөлөөллийг тогтоох зорилгоор шинжээчдийн хэсэг газар дээр нь очиж, төслийн талбай болон орчны байдалтай танилцаж, холбогдох судалгааг хийсэн болно.

Төслийн болзошгүй нөлөөллийг тогтоохдоо магадлан жагсаах аргыг ашиглаж, үр дүнг дараах хүснэгтэд үзүүлэв. Энэ арга нь төсөл хэрэгжих үед тухайн нөлөөлөл байгаа эсэх дээр тулгуурладаг ба хэрэв тухайн нөлөөлөл байвал "х"-ээр тэмдэглэдэг. Ингэхдээ тухайн нөлөөллийн хэлбэр, үргэлжлэх хугацаа, эрчим зэргийг тодруулах, мөн уг нөлөөлөл байгаль орчин, экологийн тэнцвэрт байдал, орон нутгийн нийгэм-эдийн засагт хэрхэн нөлөөлөх (шууд, шууд бус, эргэж нөлөөлөх, буцалтгүй нөлөөлөх, давхардах эсэх) байдлыг үзүүлдэг.

Хүснэгт 7. Болзошгүй нөлөөллийн хэлбэр, үргэлжлэх хугацаа, эрчим ба эх үүсвэр

Байгаль орчны үзүүлэлт	Шууд	Шууд бус	Өөрөөр зохицуулагдах	Богино хугацааны	Урт хугацааны	Буцаж нөлөөлөх	Буцалтгүй нөлөөлөх	Хүчтэй	Дунд эрэг	Бага зэрэг
<b>1. Байгалийн төрөл зүйлийн өөрчлөлт</b>										
Газрын доорх урсцын өөрчлөлт			х							
Гадаргын урсцын өөрчлөлт			х							
Ургамлын бүтцийн өөрчлөлт	х				х					х
Хөрсний элэгдэл, эвдрэл	х				х					х
Зэрлэг амьтдын орон зайн өөрчлөлт			х							
Уур амьсгалын (бичил) өөрчлөлт			х							
<b>2. Байгалийн нөөц ашиглалт</b>										
Газрын гадаргын нөөц баялаг			х							
Бэлчээрийн байдал			х							
Эрдэс түүхий эдийн нөөц			х							
Эрчим хүчний нөөц			х							
<b>3. Байгаль, орчны өөрчлөлт</b>										
Газрын доорх усны чанар, хэмжээ			х							
Гадаргын усны чанар хэмжээ			х							
Агаарын бохирдол			х							
Хөрсний бохирдол			х							
Төслийн үйл ажиллагаанаас ялгарах бохирдуулагч бодис хүний эрүүл мэндэд нөлөөлөх			х							
Дуу чимээ, шуугианы нөлөө			х		х					

Байгаль орчны үзүүлэлт	Шууд	Шууд бус	Өөрөөр зохицуулагдах	Богино хугацааны	Урт хугацааны	Буцаж нөлөөлөх	Буцалтгүй нөлөөлөх	Хүчтэй	Дунд эрэг	Бага зэрэг
<b>4. Байгалийн өнгө төрх, түүх, соёлын дурсгалт зүйл, археологи, палеонтологийн олдвор</b>										
Байгалийн үзэсгэлэнт өнгө төрх өөрчлөгдөх			x							
Ландшафтын хэлбэр, өнгө өөрчлөгдөх			x							
Тусгай хамгаалалттай газар нутагт нөлөөлөх			x							
Түүх соёлын дурсгалт зүйлд нөлөөлөх			x							
Археологи, палеонтологийн олдворт нөлөөлөх			x							
<b>5. Нийгэмд үзүүлэх нөлөө</b>										
Дэд бүтцийн хөгжилд нөлөөлөх		x			x				+	
Үйлчилгээний салбарын ү/а-нд нөлөөлөх		x			x					+
Хүн амын орлого өөрчлөгдөж, нэмэгдэх		x			x				+	
Хүн амын эрүүл мэндэд нөлөөлөх			x							
<b>6. Эдийн засагт үзүүлэх нөлөө</b>										
Татварын орлого өөрчлөгдөх	x				x		x			+
Орон нутгийн орлого нэмэгдэх	x				x		x			+
Ядуурлыг бууруулахад дэмжлэг болох	x				x		x			+
Ажлын байр нэмэгдэх	x				x		x			+
Улирлын чанартай эрэлт хэрэгцээ нэмэгдэх	x				x		x			+
<b>7. Бусад нөлөөлөл</b>										
Бохир ус хөрсөнд нэвчиж, хөрс ба грунтын усыг бохирдуулах			x							
Дүн	7	3	21	0	11	0	5	0	2	8

Төслийн болзошгүй сөрөг болон эерэг нөлөөллийн хэлбэр, хугацаа, эрчмийн үндэслэлийг дараах байдлаар гаргасан болно. Үүнд:

Шууд нөлөөлөл:

- Төслийн барилга байгууламжийн нөлөөгөөр биет хэмжээгээр хөрс, ургамлын бүрхэвч үүсмэл хэлбэршлээр солигдож, шууд, урт хугацаанд сөрөг нөлөөлнө;
- Дэд бүтцийн хөгжилд эергээр, урт хугацаагаар нөлөөлнө;
- Орон нутгийн орлого, ажлын байр нэмэгдэх зэрэгт төслийн үйл ажиллагаа явагдах хугацаанд болон цаашид эергээр нөлөөлнө;

Шууд бус нөлөөлөл:

- Үйлчилгээний салбарын үйл ажиллагаанд урт хугацаанд эерэг нөлөөлнө;

Хүчтэй нөлөөлөл:

- Болзошгүй нөлөөллийн үнэлгээ хийх явцад төслийн зүгээс хүчтэй нөлөөлөх нөлөө байхгүй байна.

#### БҮЛЭГ 4. БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТУХАЙН ЖИЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ГОЛ ЗОРИЛТ

*Зорилго:* Байгаль орчны менежментийн төлөвлөгөө (БОМТ)-ний гол зорилго нь төслийн үйл ажиллагаанаас байгаль орчин, хүний эрүүл мэндэд үзүүлж болзошгүй сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэх, сөрөг нөлөөллийг бууруулах, арилгах хэмжээг төлөвлөхөд оршино. Ингэхдээ тухайн арга хэмжээ бүрийг төсөл хэрэгжүүлэгч нь хэрэгжүүлж чадахуйц, бодитойгоор төлөвлөх нь чухал.

*Гол зорилтууд:*

- Байгаль орчны бүрэлдэхүүн хэсгүүд болон хүний эрүүл мэнд, нийгэм эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөлөл, эрсдэлээс урьдчилан сэргийлэх, сөрөг нөлөөллийг бууруулахад зайлшгүй хэрэгжүүлэх арга хэмжээг төлөвлөх;
- Төслийн үйл ажиллагаанаас агаар, хөрс, усан орчин болон ажлын байрны нөхцөлд хэрхэн нөлөөлж байгаа талаар хяналт шинжилгээ явуулах арга хэмжээг төлөвлөх;

*Хүснэгт 8. Байгаль орчныг хамгаалах төлөвлөгөөний нэгтгэл*

Арга хэмжээ	Нийт мян.төг
Сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэх, бууруулах	750.0
Орчны тохижилт, нөхөн сэргээлтийн төлөвлөгөө	1,770.0
Түүх, соёлын өвийг хамгаалах арга хэмжээ	-
Осол эрсдэлийн менежментийн төлөвлөгөө	5,500.0
Хог хаягдлын менежментийн төлөвлөгөө	2,200.0
Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр	1,096.0
Тухайн жилийн БОМТ-г хэрэгжүүлэх удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөө	-
Тухайн жилийн БОМТ-ий хэрэгжилтийг нөлөөллийн бүсийн оршин суугчдад тайлагнах төлөвлөгөө	-
<b>Нийт</b>	<b>11316.0</b>



### 5. СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ

Хүснэгт 9. Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө

№	Гол болон болзошгүй сөрөг нөлөөлөл	Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ	Сөрөг нөлөөллийн хамрах хүрээ	Хэмжих нэгж	Нэгжийн зардал (Төгрөг)	Тоо хэмжээ	Нийт зардал, мян.төг	Хэрэгжүүлэх хугацаа, давтамж	Баримтлах эрхзүйн баримт бичиг
<b>Агаарын чанарт үзүүлэх сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэх, бууруулах, арилгах арга хэмжээ</b>									
1	Агаарын бохирдол үүсэх	Ил задгай хог хаягдал шатаахгүй байх	Төслийн талбайд	тогтмол	Үйл ажиллагааны зардал		2024 он	Агаарын тухай хууль, Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хууль MNS 4585:2016	
2	Авто тээврийн хэрэгслээс хорт хий ялгарах, дуу чимээ тархах	Үйлдвэрийн үйл ажиллагаанд ашиглаж буй машин техникийг үзлэг, оношилгоонд тогтмол оруулж, засвар үйлчилгээг шаардлагын дагуу хийж гүйцэтгэж байх	Үйлдвэрийн машин	Жилд 1 удаа	Үйл ажиллагааны зардал		2024 он		
3	Дотоод орчны агаарын сөрөг нөлөөллөөс үйлдвэрийн ажилчдын эрүүл мэндэд нөлөөлөх	Агааржуулалтын тоног төхөөрөмжийн ажиллагааг тогтмол хянах, засвар үйлчилгээг тухай бүр хийж байх	Үйлдвэрийн барилга	1 иж бүрэн	Үйл ажиллагааны зардлаар		2024 он		Ажлын байрны бичил цаг уурын үзүүлэлтийн тохиромжтой хэмжээ тэдгээрийг хэмжихэд тавих ерөнхий шаардлага MNS 6999 : 2023
<b>Дүн</b>							-		
<b>Усан орчинд үзүүлэх сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэх, бууруулах, арилгах арга хэмжээ</b>									
4	Усан орчин бохирдох, Усны нөөц хомсдох	Ус ашиглах гэрээг Усны газартай байгуулах	Төслийн хүрээнд	1 удаа	Үйл ажиллагааны зардал		2024 он	“Усны тухай хууль” Ус бохирдуулсны төлбөрийн тухай хууль MNS 6561:2015 MNS 4943:2015 MNS 6734:2018 “Усны тухай хууль” БОНХАЖ-ын сайд, БХБ-ын сайдын	
5		Жил бүр Усны газраар ус ашиглуулах дүгнэлтийг гаргуулж байх	Төслийн хүрээнд	Жил бүр	Үйл ажиллагааны зардал		2024 он		
6		Ус ашиглах гэрээ, дүгнэлтийг үндэслэн усны төлбөрийг тухай бүрд нь төлж байх	Төслийн хүрээнд	Жил бүр	Гэрээний үндсэн дээр		2024 он		
7		Борооны ус хуримтлуулан дахин ашиглах зөвлөмж	Ус хэмнэх	ширхэг	-	1 удаа	500.0		2024 он
8		Ус хэмнэх технологи хэрэгжүүлэх	Иж бүрэн	ширхэг	Үйлд ажиллагааны зардал		2024 он		

№	Гол болон болзошгүй сөрөг нөлөөлөл	Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ	Сөрөг нөлөөллийн хамрах хүрээ	Хэмжих нэгж	Нэгжийн зардал (Төгрөг)	Тоо хэмжээ	Нийт зардал, мян.төг	Хэрэгжүүлэх хугацаа, давтамж	Баримтлах эрхзүйн баримт бичиг
		/ариун цэврийн өрөөнд ус хэмнэдэг сантехникийн төхөөрөмжүүдийг суурилуулах/							хамтарсан тушаал-А-230/127 тоот журам “Ус ашиглалт, хэрэглээг тоолууржуулах журам”
9		Ашиглаж буй гүний худагт тоолуур суурилуулах	Гүний худаг	Ширхэг		1	250.0	2024 он	
10		Ус хангамжийн эх үүсвэрээс 50 метрээс доошгүй зайд эрүүл ахуйн хориглолтын бүс, 200 метрээс доошгүй зайд эрүүл ахуйн хязгаарлалтын бүсийг тогтоож мөрдөж ажиллах	Төслийн талбай	удаа	Үйлд ажиллагааны зардал			2024 он	
11		ATMOR брэндийн бохир усны септик систем суурилуулах.	Төслийн талбай	1 удаа	Үйлд ажиллагааны зардал			2024 он	
<b>Дүн</b>							<b>750.0</b>		
<b>Нийт дүн</b>								<b>750.0</b>	

## 6. ОРЧНЫ ТОХИЖИЛТ, НӨХӨН СЭРГЭЭЛТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

“Газрын тухай хууль”-ийн 56.6-р зүйл: Хот, тосгоны өнгө үзэмж, эрүүл ахуйн нөхцөлийг сайжруулах, газрыг хамгаалах, нөхөн сэргээх шаардлагын дагуу газар эзэмшигч нь эзэмшилд авсан газрын 10-аас доошгүй хувийг ногоон байгууламжтай байна. Төсөл хэрэгжүүлэгч нь ойролцоогоор 597 м<sup>2</sup> талбайд ногоон байгууламжийг байгуулах шаардлагатай.

Хүснэгт 10. Орчны тохижилт, нөхөн сэргээлтийн төлөвлөгөө

№	Орчны тохижилт, цэцэрлэгжүүлэлтийн зорилт	Нөхөн сэргээлтийн арга хэмжээ	Арга хэмжээний цар хэмжээ	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Нийт зардал, төг /мян/	Хэрэгжүүлэх хугацаа давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
1	Ногоон байгууламж бий болгох	Мод тарих /хайлаас-20ш, голт бор-20ш/	Төслийн талбайн хэмжээнд	Ширхэг	40	520.0	2024 он 2024 он	Хөрс хамгаалах, цөлжилтөөс сэргийлэх тухай хууль MNS 4585:2016 Зүлэгжүүлэх талбай бэлтгэх, үр тарих, арчлах MNS 6260 : 2020
		Зүлэгжүүлэх		кг	10	1,250.0	2024 он	
<b>Нийт дүн</b>						<b>1,770.0</b>		

## 7. ТҮҮХ, СОЁЛЫН ӨВИЙГ ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ

Төслийн үйл ажиллагаатай холбоотой түүх соёлын өвийг хамгаалах ажил хийгдэхгүй болно.

## 8. ОСОЛ ЭРСДЭЛИЙН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

### Хүснэгт 11. Эрсдэлийн менежментийн төлөвлөгөө

№	Болзошгүй аюул, осол сөрөг нөлөө	Урьдчилан сэргийлэх, хамгаалах арга хэмжээ	Арга хэмжээний цар, хэмжээ	Тоо хэмжээ	Нэгжийн өртөг	Нийт зардал (мян.төг)	Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж	Баримтлах стандарт, аргачлал
	1	2	3	4	5	6	7	8
1	Байгалийн болзошгүй гамшиг, аюулт үзэгдлээс үүдэн төслийн үйл ажиллагаанд сөргөөр нөлөөлөх, дам нөлөөллөөр хүрээлэн буй орчныг бохирдуулах	Хөдөлмөр хамгаалал аюулгүй ажиллагаа, гал түймрээс урьдчилан сэргийлэх сургалт сурталчилгаа, болзошгүй аюулын үед авах арга хэмжээг төслийн нийт ажилтан албан хаагчдад тогтмол хугацаанд танилцуулах	Төслийн нийт ажилчдад	14 ажилчин	-	УАЗ	2024 он	ХАБЭА
2		“Гамшгийн эрсдэлийн нарийвчилсан үнэлгээ”- мэргэжлийн байгууллагаар хийлгүүлэх	Төслийн хүрээнд	1 удаа	Үйл ажиллагааны төсөвт суулгах		2024 он	ЗГ-ын 2020 оны 190-р тогтоол
3		“Гамшгийн эрсдэлийн нарийвчилсан үнэлгээ”-г үндэслэн “Гамшгаас хамгаалах төлөвлөгөө” боловсруулан батлуулж, мөрдөн ажиллах, ажилтан бүрийн ажил үүргийн хуваарийг гаргаж, зааварчилга өгөх.	Төслийн хүрээнд	Удаа	Үйл ажиллагааны төсөвт суулгах		2024 он	Гамшгаас хамгаалах хууль
4		Түр цугларах талбайн байршлыг тэмдэгжүүлэн тогтоолгох;	Төслийн хүрээнд	-	Үйл ажиллагааны төсөвт суулгах		Үйл ажиллагааны турш	Гамшгаас хамгаалах хууль
<b>Гал түймрээс урьдчилан сэргийлэх</b>								
5	Гал түймрийн эрсдэлээс урьдчилан сэргийлэх	Нийслэлийн онцгой байдлын газраас галын аюулгүй байдлын дүгнэлтийг гаргуулах	Төслийн хүрээнд	-	Үйл ажиллагааны зардал		2024 он	ААНБ, барилга байгууламжид гал унтраах анхан шатны багаж хэрэгслийн зайлшгүй байх шаардлага MNS 5566 : 2020
6		Галын багаж хэрэгсэл авч ашиглахад бэлэн байдлаар байрлуулах (галын хор, гал унтраагч, усан шүршүүр, гал унтраах хуурай хэрэгсэл, хөөс, нүүрсхүчлийн хий гэх мэт) бүрэн бүтэн, хэвийн ажиллагаанд хяналт тавих	Үйлдвэрийн талбай гадан талбайд	2 байршилд	-	5000.0	2024 он	
7		Ажилчдын үйл ажиллагаанд галын аюулын аюулгүй байдлыг хангах дүрэм журмыг баримтлуулах;	Төслийн хүрээнд		Үйл ажиллагааны зардал		2024 он	

№	Болзошгүй аюул, осол сөрөг нөлөө	Урьдчилан сэргийлэх, хамгаалах арга хэмжээ	Арга хэмжээний цар, хэмжээ	Тоо хэмжээ	Нэгжийн өртөг	Нийт зардал (мян.төг)	Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж	Баримтлах стандарт, аргачлал
1	2	3	4	5	6	7	8	
<b>Хөдөлмөр хамгаалал, эрүүл ахуй</b>								
8	Үйлдвэрлэлийн гэнэтийн ослын улмаас хүний эрүүл мэнд, амь насанд сөргөөр нөлөөлж, олборлолтын үйл ажиллагаа доголдох, зогсох	Ажилчдыг эрүүл мэндийн үзлэг шинжилгээнд хамруулах төлөвлөлтийг хийх, хэрэгжүүлэх	Нийт ажилчид 14 хүн	Жилд нэг удаа	ХАБЭА зардал		2024 он	Гамшгаас хамгаалах хууль MNS 5080:2023
9		Ажилчин нэг бүрийг хөдөлмөр хамгааллын хувцас, багаж хэрэгслээр хангах	Нийт ажилчид 14 хүн	Жилд нэг удаа	ХАБЭА зардал		2024 он	
10		Хөдөлмөр хамгаалал аюулгүй ажиллагааны дүрэм журмыг сахиулж, хэрэгжилтэд хяналт тавих	Төслийн хүрээнд	Тогтмол	Үйл ажиллагааны зардлаар		2024 он	
11		Ажилчдын хувийн ариун цэврийг тогтмол сахиулах зорилгоор үйлдвэрийн амрах байранд шүршүүр хийж, угаалгын машин байршуулах.	Төслийн хүрээнд	1 удаа	Үйл ажиллагааны зардлаар		2024 он	
<b>Цахилгааны эрсдэл</b>								
12	Цахилгаанаас үүдэлтэй эрсдэл хөдөлмөр хамгаалал	Цахилгааны бүх тоног төхөөрөмжүүд, шугамуудад анхааруулсан тэмдэг байрлуулах	Үйлдвэрийн хүрээнд	1 удаа	-	500.0	2024 он	
13		Цахилгааны бүх утас, кабель болон цахилгаан гар багажуудын утас ил гарсан, шалбарсан эсэхийг шалгах, зөөврийн гар багажуудыг ашиглаж болох цахилгаан хүчдэлийн зөвшөөрсөн дээд хэмжээг дагаж мөрдөх	Төслийн хүрээнд	Тогтмол	Үйл ажиллагааны зардлаар		2024 он	Цахилгааны аюулгүй ажиллагаа MNS 5151:2002
14		Чийгтэй орчинд ажиллах бүх цахилгаан тоног төхөөрөмжид давхар тусгаарлалт, газардуулга хийх зэрэг болно.	Төслийн хүрээнд	Тогтмол	-	УАЗ		2024 он
Нийт							5,500.0	

### 9. ХОГ, ХАЯГДЛЫН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

Хүснэгт 12. Хог хаягдлын менежментийн төлөвлөгөө

№	Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ	Сөрөг нөлөөллийн хамрах хүрээ	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Нэгжийн зардал мян.төг	Нийт зардал, мян.төг	Хэрэгжүүлэх хугацаа, давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
1	Хог хаягдлыг ангилан ялгах зориулалтын цэгийг тохижуулах	Хог хаягдлын цэг	Иж бүрэн	1 удаа	2 000.0	2 000.0	2024 он	БОАЖ-ын сайдын А/433 тогтоол Хог хаягдлын тухай хууль
2	Үйлдвэрийн эзэмшлийн талбайд ил задгай хаягдсан хогийг ангилан ялгаж цэвэрлэж байх	Үйлдвэрийн ойр орчмын 100 метрт	Тогтмол	Үйл ажиллагааны зардал		2024 он		
3	Дахин боловсруулагдах хог хаягдлыг хоёрдогч түүхий эд авах байгууллага, нэгжид нийлүүлэх	Дахин ашиглагдах хог хаягдал	Тогтмол	Үйл ажиллагааны зардал		2024 он		
4	Хог хаягдлын цэгт ариутгал, халдваргүйжүүлэлтийг тогтмол хийх, орчныг бохирдуулахаас сэргийлэх	Хог хаягдлын цэгт	Тогтмол	Улиралд 1 удаа	-	200.0	2024 он	
5	Шингэн хог хаягдал хадгалах зориулалтын цэгтэй болох	Шингэн хог хаягдлын	Тогтмол	Үйл ажиллагааны зардал		2024 он		
6	Үүссэн аюултай хог хаягдлаа эрх бүхий байгууллагад, эсхүл тогтоосон тусгай цэгт хүлээлгэн өгөх	Аюултай хог хаягдал	Тогтмол	Үйл ажиллагааны зардал		2024 он		
7	Хог хаягдлыг бууруулах, ангилах, дахин ашиглах, зүй зохистой хаях дадал зуршлыг хэвшүүлэх сургалт хийх	Үйлдвэрийн ажилчдад	удаа	Үйл ажиллагааны зардал		2024 он	Засгийн газрын 116 тогтоол	
8	Үүсэх хог хаягдлын төрөл, кодыг ЗГ-ын 116 тогтоолд заасан хог хаягдлын кодчилсон жагсаалтын дагуу тогтоосон байх	Төслөөс үүсэх хог хаягдал	удаа	Үйл ажиллагааны зардал		2024 он		
9	Аж ахуйн нэгж, байгууллага нь хог хаягдал цуглуулах, тээвэрлэх, дахин боловсруулах эрх бүхий иргэн, аж ахуйн нэгж, байгууллагатай хог тээврийн үйлчилгээний гэрээ байгуулах	Төслөөс үүсэх хог хаягдал	Удаа	Гэрээний үнийн дүнгээр		2024 он		
10	Малын гаралтай хаягдлыг дахин боловсруулах үйлдвэрүүдтэй хамтран ажиллах гэрээ байгуулах	Малын гаралтай хог хаягдал	удаа	Үйл ажиллагааны зардал		2024 он		
<b>Нийт дүн</b>						<b>2,200.0</b>		

### 10. ОРЧНЫ ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭНИЙ ХӨТӨЛБӨР

Хүснэгт 13. Орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийн хуваарь

Хяналт шинжилгээ хийх үзүүлэлт	Хяналтын цэгийн байршил	Хугацаа давтамж	Давтамжийн тоо	Нэгжийн зардал, төг	Нийт зардал, төг	Хууль, бодлого, стандарт
<b>Агаарын чанар</b>						
CO <sub>2</sub> , NO <sub>2</sub> , SO <sub>2</sub> Тоос нийт (PM10, PM2.5) Дуу шуугиан хэмжээ	<ul style="list-style-type: none"> <li>➤ Үйлдвэрийн байр дотор -2 цэг - 47°53'10.55"N; 106°35'32.90"E - 47°53'10.16"N; 106°35'32.33"E</li> <li>➤ Төслийн талбайн хашаан дотор-2 цэг - 47°53'9.62"N; 106°35'31.71"E - 47°53'8.41"N; 106°35'34.22"E</li> </ul>	Улиралд 1 удаа	4 цэгт	176.0	176.0	MNS 4585:2016 Агаарын чанар. Техникийн шаардлага
<b>Хөрс</b>						
Нянгийн шинжилгээ /Нянгийн ерөнхий тоо, гэдэсний бүлгийн нянгийн тоо, гэдэсний бүлгийн эмгэг төрөгч нян, E.Coli халуунд тэсвэртэй гэдэсний бүлгийн нянгийн тоо/	<ul style="list-style-type: none"> <li>➤ Хогийн цэг – 1 цэг - 47°53'8.86"N; 106°35'32.22"E</li> </ul>	Улиралд 1 удаа	1 цэгт	35.0	140.0	- MNS 3297:2019, “Байгаль хамгаалал. Хөрс. Хот суурин газрын хөрсний эрүүл ахуйн аюулгүйн үзүүлэлт, бохирдлыг үнэлэх”
Хөрсний хүнд металлууд	<ul style="list-style-type: none"> <li>➤ Төслийн талбайн ил гарсан хөрснөөс-1 цэг - 47°53'8.86"N; 106°35'32.22"E</li> </ul>	Улиралд 1 удаа	1 цэгт	30.0	120.0	- MNS 5850:2019, “Хөрсний чанар, хөрсөнд агуулагдах бохирдуулагч бодисын зөвшөөрөгдөх дээд хэмжээ”
<b>Усны чанар</b>						
Усны ерөнхий хими, Бактериологи	<ul style="list-style-type: none"> <li>➤ Унд, ахуйн ус - 47°53'9.07"N; 106°35'33.21"E</li> </ul>	Улиралд 2 удаа	1 цэгт	165.0	660.0	- MNS 0900:2018 “Хүрээлэн буй орчин. Эрүүл мэндийг хамгаалах. Аюулгүй байдал. Ундны ус. Эрүүл ахуйн шаардлага, чанар, аюулгүй байдлын үнэлгээ”
<b>Нийт дүн</b>					<b>1096.0</b>	



Зураг 12. Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр



## 11. ТУХАЙН ЖИЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨГ ХЭРЭГЖҮҮЛЭХ УДИРДЛАГА ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨ

Хүснэгт 14. Тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөө

№	Төлөвлөсөн арга хэмжээ	Урьдчилан тооцсон төсөв	Хэрэгжүүлэх хугацаа хуваарь			Хариуцсан албан тушаалтан	Тайлбар
			2024 он				
			Сар	Сар	Сар		
1	2	3	4	5	6	7	
1	Газрын төлөв байдал, чанарын улсын хянан баталгааг эрх бүхий байгууллагаар гүйцэтгүүлэх (5 жилд 1 удаа).	Гэрээт ажлын дүнгээр	8-р сар			Үйлдвэрийн дарга	Газрын тухай хууль
2	Төсөл хэрэгжих орон нутгийн удирдлагатай нийгмийн хариуцлагын хүрээнд хамтран ажиллах.	Тохиролцох			9-10 сар	Үйлдвэрийн дарга	Нийгмийн хариуцлагын гэрээ Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хуулийн 14.1.3
3	Байгаль орчны удирдлага зохион байгуулалтын арга хэлбэрийг үйл ажиллагаандаа хэрэгжүүлэх чиглэлээр үүрэг хариуцлагын дотоод журам тогтоож мөрдөх	Дотоод төлөвлөлтөөр	4-р сар			Үйлдвэрийн дарга	Байгаль орчныг хамгаалах тухай хууль
4	Байгаль орчныг хамгаалах төлөвлөгөө, орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээг зохих хугацаанд хийж гүйцэтгэх ба биелэлтийг жил бүр дүгнэж, тухайн жилийн БОМТ-г батлуулж байх	Үйл ажиллагааны зардал			11-12 сар	Байгаль орчны мэргэжилтэн	Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хуулийн 14.12-р заалт, БОАЖ-ын сайдын 2019 оны А/618 тоот тушаал “Байгаль орчны менежментийн төлөвлөгөө боловсруулах, хянан батлах, тайлагнах журам
10							
<b>Нийт зардал</b>		-					

## 12. ТУХАЙН ЖИЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТИЙГ НӨЛӨӨЛЛИЙН БҮСИЙН ОРШИН СУУГЧДАД ТАЙЛАГНАХ ТӨЛӨВЛӨГӨӨ

Хүснэгт 15. Тухайн жилийн БОМТ-ний хэрэгжилтийг нөлөөллийн бүсийн оршин суугчдад тайлагнах төлөвлөгөө

№	БОХТ-ний биелэлтийг тайлагнахад оролцогч талууд	Тайлагнах хэлбэр	Мэдээллийн агуулга	Зохион байгуулах хугацаа тов	Тайлагнах зардал мян.төг	Хариуцан зохион байгуулах албан тушаалтан/ажилтан	Зохион байгуулах газар
1	2	3	4	5	6	7	
1	Нийслэлийн Байгаль орчны газар	<a href="https://eic.mn/envmng/">https://eic.mn/envmng/</a> буюу Байгал орчны мэдээллийн санд оруулах	Тухайн жилд байгаль орчны талаар хийгдсэн ажил нөхөн сэргээсэн ажлын акт болон холбогдох материал	Тухайн оны 11 - р сарын 1 дотор	Үйл ажиллагааны зардал	БО ажилтан, Менежер	-
2	Төрийн захиргааны төв байгууллага	<a href="https://eic.mn/envmng/">https://eic.mn/envmng/</a> буюу Байгал орчны мэдээллийн санд оруулах, тамгалуулах	Тухайн жилд байгаль орчны талаар хийгдсэн ажил нөхөн сэргээсэн ажлын акт болон холбогдох материал	Тухайн оны 12-р сарын 1 дотор	Үйл ажиллагааны зардал	БО ажилтан, Менежер	Төрийн захиргааны төв байгууллага
<b>Нийт дүн</b>					-		